



**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2016 оны 03 сарын 07 өдөр

Дугаар 10

Алтай

Хөрөнгө актлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2002 оны 55 тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Аймгийн Цагдаагийн газрын данс хөрөнгөнд бүртгэлтэй хавсралтанд дурдсан цаашид ашиглалтын шаардлага хангахгүй болсон хөрөнгийг актлаж устгахыг зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгө актлаж устгах ажлыг зохион байгуулж, дүнг танилцуулахыг аймгийн Засаг дарга /О.Амгаланбаатар/, Орон нутгийн өмчийн алба /Л.Ганхуяг/ нарт даалгасугай.

ДАРГА  А.ДЭЛГЭРЖАРГАЛ





72

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2016 оны 03-р сарын 07-ны
өдрийн 10-р тогтоолын хавсралт

Цагдаагийн газрын актлах хөрөнгийн жагсаалт

д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтанд орсон он	Ашигласан жил	Тоо хэмжээ	Анхны өртөг	Бүгд үнэ	Элэгдэл	Үлдэгдэл өртөг
1	Алтай сумын Бургастай боомтын Цагдаагийн хуучин кабоны барилга	2001	14	1	7275000	7275000	4041665	3233335
2	Уаз Пургон 09-99ГАА	2013	2	1	20000000	20000000	3333333	16666667
Дүн					2	27275000	7374998	19900002

74